

Аудитын бус гэрээт ажлын мөн чанар

Essential and Characteristics of Non-audit Service

Н. Дамдиндорж¹, Э. Ундармаа²

Хураангуй

Аудитын бус гэрээт ажил нь гэрээт ажлын нэг төрөл бөгөөд аудитын гэрээт ажлаас өөрийн онцлог шинжийг агуулсан, мөрдөх тусдаа стандарттай, хэрэгжүүлэх горим болон тайлангийн бүтэц, дүгнэлтийн агуулга зэрэг нь ялгаатай байдаг. Тиймээс бид аудитын бус гэрээт ажлын үндсэн төрөл, мөн чанарыг тодорхойлж, уг гэрээт ажлыг аудит буюу санхүүгийн тайлангийн аудитаас ямар онцлог шинж чанартай болохыг тодорхойлох зорилгоор энэхүү онолын судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Урьдчилсан байдлаар харахад аудитын бус гэрээт ажилд олон төрлийн гэрээт ажлууд хамаарах бөгөөд мөн үйлчлүүлэгчид өгч байгаа баталгааны түвшин, дүгнэлт илэрхийлэх хэлбэр зэрэг нь хоорондоо болоод аудитын гэрээт ажлаас ялгаатай. Харин аудитын бус гэрээт ажлыг гүйцэтгэхэд ашигладаг аудитын тохиромжтой горим, гэрээт ажилтай холбоотой эрсдлийг хэрхэн шийдвэрлэдэг нь сонирхолтой байна.

Түлхүүр үгс: аудит, аудитын бус гэрээт ажил, аудитын холбогдох үйлчилгээ, баталгаажуулах гэрээт ажил, баталгаа, дүгнэлт

Abstract

Non-audit contract work is a type of contract work, and it has its characteristics, separate standards to be followed, implementation procedure, report structure, and conclusion content that are different from audit contract work. Therefore, we performed this theoretical research to determine the main types and nature of non-audit contractual work and to determine the characteristics of this contractual work from audit or financial statement audit. From a preliminary perspective, non-audit engagements involve a variety of engagements and differ from audit engagements in terms of the level of assurance provided to the client and the form of opinion. However, it is interesting to see the appropriate audit procedures for performing non-audit contract work and how contract work disputes are resolved.

Keywords: audit, non-audit service, audit-related service, assurance engagement, assurance, opinion

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: damdindorj.n@num.edu.mn

² МУИС-ийн Бизнесийн Сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: undarmaae@num.edu.mn

Аудитын бус гэрээт ажлын талаарх ойлголт

Аудитын салбарт гэрээт ажлыг аудитын гэрээт ажил, аудитын бус гэрээт ажил гэж ангилах бөгөөд аудитын бус гэрээт ажлууд нь маш өргөн хүрээтэй зүйл юм. Энэ гэрээт ажил ерөнхийдөө баталгаажуулах гэрээт ажил, холбогдох үйлчилгээний гэрээт ажил гэсэн төрөлтэй байдаг (Дүрслэл 1). Эдгээр гэрээт ажлуудыг ойлгож, ялгахын тулд гэрээт ажил тус бүрд дурдагдах баталгааны түвшингийн төрөл, онцлогыг судлах шаардлага үүсдэг ба Баталгаажуулах Гэрээт Ажлын Олон Улсын Стандарт 3000 буюу АОУС 3000-д аудитор гүйцэтгэсэн гэрээт ажилдаа хэрэгжүүлсэн горим, олж авсан нотолгоо зэргээс хамааран эрсдлийг хэрхэн бууруулж чадсанаас шалтгаалан дараах хоёр төрлийн баталгааны түвшин байдаг.


Ул үндэслэлтэй баталгаа - гэрээт ажлын эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц хамгийн бага түвшин хүртэл бууруулж, аудиторын дүгнэлтийн үндэслэл болж чадахуйц хангалттай хэмжээний зохистой нотолгоог бий болгох аудитын горимуудыг хэрэгжүүлснээр энэ төрлийн баталгааг үйлчлүүлэгчид өгдөг бөгөөд өөрөөр хэлбэл аудитын үйлчилгээнээс гаргадаг баталгаа юм.

Хязгаарлагдмал баталгаа - гэрээт ажлын эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшин хүртэл бууруулж, гэрээт ажлын дүгнэлтийн үндэслэл болох хангалттай хэмжээний зохистой нотолгоог бий болгох аудитын хязгаарлагдмал горимуудыг хэрэгжүүлснээр энэ төрлийн баталгааг үйлчлүүлэгчид өгдөг. Уг гэрээт ажлын төрөлд ихэнх аудитын бус гэрээт ажил ордог боловч зарим баталгаажуулах гэрээт ажил ул үндэслэлтэй баталгаа олгодог.

Аудитын холбогдох үйлчилгээний төрөл, агуулга

Холбогдох үйлчилгээ гэдэг нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийхээс бусад аудитын компани үйлчлүүлэгч байгууллагад үзүүлэхээр санал болгож байгаа мэргэжлийн аливаа үйлчилгээг хэлдэг бол баталгаажуулах гэрээт ажил нь аудитор тухайн шалгагдаж байгаа асуудал нь тохиромжтой шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж эсвэл хэмжиж, өөрийн санал дүгнэлтээ ул үндэслэлтэй эсвэл хязгаарлагдмал түвшний баталгаагаар зорилтот хэрэглэгчдэд гаргахыг хэлдэг. Шалгагдаж буй асуудлын иж бүрэн, үнэн зөв зэрэг найдвартай байдлыг үйлчлүүлэгчийн удирдлага хариуцдаг.

Дүрслэл 1. Аудитын бус гэрээт ажлын төрөл, ангилал



Аудитын холбогдох үйлчилгээ нь аудиттай адил өндөр түвшний баталгааг өгдөггүй боловч энэ үйлчилгээний харилцаанд үйлчлүүлэгч байгууллагын удирдлага өндөр үүрэг хариуцлага хүлээдэг бөгөөд үүнд тохиромжтой санхүүгийн тайлагналын үзэл баримтлалаар бүртгэл хөтөлж тайлагнах, санхүүгийн тайлан нь үнэн зөв толилуулж, тодруулагдсан байх, дотоод хяналтыг үр ашигтай зохион байгуулж хэрэгжүүлэх, залилангаас урьдчилан сэргийлж, түүнийг илрүүлэх, үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа нь хууль, журамд нийцэж байгаа эсэх, бүртгэлийн болон анхан шатны баримтын үнэн зөв, иж бүрэн байдлыг хангах зэрэг олон үүрэг хүлээдэг. Аудитын холбогдох үйлчилгээнд дараах зүйлс багтана.

Нягтлах гэрээт ажил - Санхүүгийн мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлгүй болох талаар хязгаарлагдмал баталгааны түвшинг өгдөг бөгөөд нягтлах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ аудиттай адил санхүүгийн тайлан нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо цуглуулах аудитын горимуудыг хэрэгжүүлдэггүй. Нягтлах гэрээт ажилд ихэвчлэн асуулга болон шинжилгээний горимыг гүйцэтгэх ба аудитын гэрээт ажилд хамаардаг хяналтын тест, нарийвчилсан тестүүдийг ашигладаггүй.

Тохиролцсон горимоор гүйцэтгэх гэрээт ажил - Санхүүгийн мэдээлэл эсвэл үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар бодитой дүгнэлт гаргахын тулд аудитор болон үйлчлүүлэгч хооронд тохирсон горимыг хэрэгжүүлэхийг хэлнэ. Аудитор энэ гэрээт ажилд ямар нэг дүгнэлт болон баталгаа өгдөггүй бөгөөд зөвхөн үр дүн, хэрэгжүүлсэн горимыг тайлагнадаг. Аудиторын тайланд үйлчлүүлэгч өөрөө

дүгнэлт өгч, тайлантай холбоотой хариуцлагыг хариуцдаг. Энэ төрлийн гэрээт ажлын тайлан нь ихэвчлэн дотоод мэдээлэл хэрэглэгчид зориулагдсан байдаг ба жишээлбэл дотоод хяналтын системийг үнэлэх гэрээт ажил ордог.

Эмхэтгэх гэрээт ажил - Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлан эсвэл бусад мэдээллийг бэлтгэх үүрэг хүлээх ба аудитын мэдлэг туршлагаас илүүтэй нягтлан бодох бүртгэлийн мэдлэг туршлагаа ашиглан уг гэрээт ажлыг гүйцэтгэдэг. Энэ ажилд аудиторос ихэвчлэн дүгнэлт болон баталгаа өгөхийг шаардахгүй бөгөөд зарим үед тайлан бичихийг мөн шаардахгүй байж болдог. Жишээлбэл татварын бүртгэл, тооцоолол хийх гэрээт ажил байна.

Нягтлах гэрээт ажил нь санхүүгийн мэдээлэл болон бусад мэдээлэлд аудит хийхгүйгээр шалгах үйл ажиллагаа бөгөөд баталгааны түвшин нь аудиттай харьцуулахад хязгаарлагдмал байдаг. Нягтлах гэрээт ажлын хамгийн түгээмэл хэлбэрүүд нь due diligence буюу зохих шалгалтын гэрээт ажил, санхүүгийн түүхэн мэдээллийг нягтлах гэрээт ажил, завсрын санхүүгийн мэдээллийг нягтлах гэрээт ажил зэрэг багтана.

АОУС 2400-д аудитор санхүүгийн тайлан нь материаллаг буруу илэрхийлэлгүй, нягтлан бодох бүртгэлийн зохих шалгууртай нийцэж байгаа эсэхэд итгэж, шинжилгээний горим болон асуулгын горимыг хэрэгжүүлснээр үйлчлүүлэгчид хязгаарлагдмал баталгаа өгөх гэрээт ажлыг санхүүгийн түүхэн мэдээллийг Аудитын бус гэрээт ажил гэнэ. Энэ гэрээт ажил нь аудиттай харьцуулахад бага нотолгоо шаарддагийн учир нь баталгааны түвшин доогуур байдаг бөгөөд гэрээт ажлыг гүйцэтгэх багийн гишүүд цөөн тооны байж болох ч илүү их туршлагатай

гишүүдээр багаа бүрдүүлэх нь зохимжтой юм. Нягтлах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ аудитор дараах зүйлсийг гэрээт ажлын захидалд тусгасан байна.

- Холбогдох ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх (Мэргэшсэн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм),
- Шалгаж байгаа зүйлд материаллаг буруу илэрхийлэл байж магадгүй гэсэн мэргэжлийн үл итгэх үзлээр гэрээт ажлыг төлөвлөж, гүйцэтгэх,
- Шинжилгээний горим, асуулгын горимоор хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах,
- Мэргэжлийн үнэлэмжийг ашиглах зэрэг болно.

Санхүүгийн түүхэн мэдээллийг нягтлахдаа аудитор эхлээд санхүүгийн тайлан дахь материаллагын түвшинг тодорхойлох, компанийн бизнесийн орчин болон тухайн салбарын талаар шаардлагатай мэдээллийг олж авах, санхүүгийн тайлан бэлтгэхэд ашигладаг нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга аргачлалыг судлах, санхүүгийн тайланд нөлөөлөх засаглах удирдлагын шийдвэртэй танилцах, бүртгэлийн мэдээллийн иж бүрэн байдлыг тодорхойлох зэрэг үйл ажиллагааг хийнэ. Энэ нягтлах гэрээт ажилд шинжилгээний горимыг хэрэглэх

бөгөөд өмнөх жилүүдийн санхүүгийн тайланг хооронд нь харьцуулах, өмнөх жилүүдийн санхүүгийн тайланг жил бүрийн төсөөлсөн үр дүнтэй харьцуулах, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зохих хандлагын дагуу байгаа эсэхийг судлах зэрэг байдаг. Мөн түүнчлэн уг гэрээт ажилд дараах горимуудыг хэрэгжүүлж болдог. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн аудитортой ярилцах,
- Удирдлагын танилцуулгын захидал авах,
- Нягтлан бодох бүртгэлийн бодлого тохиромжтой эсэхийг судлах,
- Ажилчдаас асуулга авах,
- Холбоотой талуудын ажил гүйлгээ болон хамаарлыг тодорхойлох,
- Тасралтгүй байх зарчмыг үнэлсэн удирдлагын үнэлгээг шалгах,
- Хэрэв зарга маргаан, залилан байгаа бол тэдгээрийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг судалж тайлагнах эсэхийг удирдлагатай зөвлөлдөх зэрэг байж болно.

Хэрэв аудитор санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэл оршин байгаа гэж үзсэн бол нягтлах гэрээт ажлын цар хүрээг өргөтгөх нь зүйтэй юм. Уг ажлыг гүйцэтгэж дуусаад гэрээт ажлын тайланг бэлтгэдэг бөгөөд тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн түүхэн мэдээллийг нягтлах гэрээт ажлын тайлангийн бүтэц

Нягтлах гэрээт ажлын тайлан (өөрчлөлтгүй саналтай)	Нягтлах гэрээт ажлын тайлан (өөрчлөлттэй саналтай)
Хаяг	Хаяг
Санхүүгийн тайлан	Санхүүгийн тайлан
Удирдлагын үүрэг хариуцлага	Удирдлагын үүрэг хариуцлага
Аудиторын үүрэг хариуцлага	Аудиторын үүрэг хариуцлага
	Саналын үндэслэл
Санал	Өөрчлөлттэй санал
Бусад хууль, зохицуулалтын шаардлага	Бусад хууль, зохицуулалтын шаардлага
Аудиторын гарын үсэг	Аудиторын гарын үсэг
Тайлангийн огноо	Тайлангийн огноо
Аудиторын хаяг	Аудиторын хаяг

Эх сурвалж: АОУС 2400

нь шалгасан бүх асуудлын хүрээнд үнэн зөв илэрхийлэгдсэн эсвэл шалгасан зарим асуудал үнэн зөв илэрхийлэгдээгүй гэсэн тайлангийн хэлбэрүүд байна (Хүснэгт 1).

АОУС 2410 нь завсрын санхүүгийн мэдээллийг нягтлах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ аудитор дагаж мөрдөх стандарт бөгөөд завсрын хугацааны мэдээлэл гэдэг нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаас бусад хугацаагаар тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн мэдээллийг хэлнэ. Жишээлбэл манай улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллага хагас жилээр санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээсэн байдаг бөгөөд энэхүү санхүүгийн мэдээллийг завсрын санхүүгийн мэдээлэл гэж үзэж болно. Уг гэрээт ажлыг гүйцэтгэж байгаа аудитор болон аудитын компани нь жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж байгаатай адил дараах зүйлсийг гүйцэтгэвэл зохино.

- Аудиттай адил ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөх,
- Тохиромжтой чанарын хяналтын горимыг хэрэгжүүлэх,
- Мэргэжлийн үл итгэх үзлээр нягтлах ажлыг төлөвлөх, гүйцэтгэх,
- Гэрээт ажлын нөхцөлүүдийг гэрээт ажлын захидалд тохиролцох,
- Гэрээт ажлыг стандартын дагуу хийснийг батлах нотолгоо цуглуулах,
- Гэрээт ажлын дүгнэлтийг дэмжих хангалттай баримтжуулалт хийх зэрэг багтана.

Өмнө дурьдсанчлан нягтлах гэрээт ажлын хувьд үйлчлүүлэгч байгууллагын удирдлага олон зүйлсийн хувьд хариуцлага хүлээдэг, аудитын хязгаарлагдмал горимуудыг шалгалтын явцад хэрэгжүүлдэг зэргээс шалтгаалан аудитор мэдээлэл хэрэглэгчид

хязгаарлагдмал баталгааны түвшинг өгдөг. Завсрын санхүүгийн мэдээллийг нягтлах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ аудитор дараах горимуудыг хэрэгжүүлж болно.

- Санхүүгийн тайлан дахь буруу илэрхийллийн эрсдлийг үнэлэх, нягтлах гэрээт ажилд тохиромжтой аудитын горимыг сонгохын тулд байгууллагын үйл ажиллагаа, бизнесийн орчин, дотоод хяналтын талаар ойлголттой болох,
- Нягтлах гэрээт ажлыг дүгнэхэд шаардлагатай нотолгоо бий болгох шинжилгээний горим болон асуулгын горимыг гүйцэтгэх,
- Хэрэв шалгалтын явцад аудиторын анхаарлыг татсан зүйл байгаа бол аудитор шинжилгээний болон асуулгын горимоос бусад горимуудыг хэрэгжүүлэх,
- Аудитор үйлчлүүлэгч байгууллагын удирдлагаас балансын дараах үйл явдал болон тасралтгүй байх зарчим хэрэгжиж байгааг үнэлсэн үнэлгээ байгаа эсэхийг тодруулах,
- Аудитор дотоод хяналт үр ашигтай эсэх, санхүүгийн мэдээлэл нь зохих нягтлан бодох бүртгэлийн үзэл баримтлалын дагуу толилуулагдаж, тодруулагдсан эсэх, залруулагдаагүй буруу илэрхийлэл нь материаллаг бус эсэх, бүх тодруулах шаардлагатай зүйлс зохистой байдлаар тодруулагдсан эсэх талаар удирдлагын танилцуулгын захидал авах зэрэг болно.

Баталгаажуулах гэрээт ажлын
төрөл, агуулга

Баталгаажуулах гэрээт ажил гэдэг нь аудитор тухайн шалгагдаж байгаа асуудал нь тохиромжтой шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж эсвэл хэмжиж, өөрийн санал дүгнэлтээ ул үндэслэлтэй эсвэл

Хүснэгт 2. Завсрын санхүүгийн мэдээллийг нягтлах гэрээт ажлын тайлангийн бүтэц

Нягтлах гэрээт ажлын тайлан (өөрчлөлтгүй саналтай)	Нягтлах гэрээт ажлын тайлан (өөрчлөлттэй саналтай)
Хаяг	Хаяг
Танилцуулга	Танилцуулга
Удирдлагын үүрэг хариуцлага	Удирдлагын үүрэг хариуцлага
Аудиторын үүрэг хариуцлага	Аудиторын үүрэг хариуцлага
	Саналын үндэслэл
Санал	Өөрчлөлттэй санал
Аудиторын гарын үсэг	Аудиторын гарын үсэг
Тайлангийн огноо	Тайлангийн огноо
Аудиторын хаяг	Аудиторын хаяг

Эх сурвалж: АОУС 2410

хязгаарлагдмал түвшний баталгаагаар зорилтот хэрэглэгчдэд гаргахыг хэлдэг. Шалгагдаж буй асуудлын иж бүрэн, үнэн зөв зэрэг найдвартай байдлыг үйлчлүүлэгчийн удирдлага хариуцдаг. Аудитор гэрээт ажлын тайланд өөрийн гүйцэтгэсэн хэмжилт эсвэл үнэлгээний үр дүнг санал болон саналын үндэслэлтэй хамт тусгах бөгөөд уг санал дүгнэлт нь тухайн асуудлын талаарх ул үндэслэлтэй эсвэл хязгаарлагдмал баталгаагаар хангагдсан байдаг. Баталгаажуулах гэрээт ажлыг гүйцэтгэх дараалал нь аудитор юуны түрүүнд шалгах асуудлыг тодорхойлж, үнэлгээний тохиромжтой шалгуур (жишээлбэл, хууль эсвэл нягтлан бодох бүртгэлийн стандарт)-ыг сонгож, хангалттай хэмжээний зохистой нотолгоо цуглуулж, уг нотолгоонд үндэслэн өөрийн саналыг тусгасан тайлан бичих гэсэн дараалалтай байдаг. Зарим гэрээт ажлын хувьд эдгээр алхамуудаас гүйцэтгэхэд хамгийн төвөгтэй нь үнэлгээний тохиромжтой шалгуурыг тодорхойлох байж болох юм. Баталгаажуулах гэрээт ажлыг дотор нь хоёр ангилж болно.

1. Баталгаажуулалт – Аудитороос бусад этгээд шалгагдаж байгаа асуудлыг тухайн шалгууртай нийцэж байгаа эсэхийг үнэлэх эсвэл хэмжихийг хэлнэ.
2. Шууд гэрээт ажил – Аудитор шалгагдаж

байгаа асуудлыг тухайн шалгууртай нийцэж байгаа эсэхийг үнэлэх эсвэл хэмжихийг хэлнэ.

Үйлчлүүлэгчийн удирдлагын гаргасан батламж мэдэгдэл нь үнэн зөв илэрхийлэгдээгүй, баталгаажуулж байгаа асуудал нь материаллагаар буруу илэрхийлэгдсэн, баталгаажуулах асуудлын шалгуур нь тохиромжтой бус тохиолдолд аудитор хязгаарлалттай эсвэл сөрөг санал дүгнэлт илэрхийлэх бол баталгаажуулах ажлын цар хүрээг хязгаарлах, баталгаажуулж байгаа асуудал нь зохистой бус үед аудитор хязгаарлалттай санал дүгнэлт эсвэл санал дүгнэлт илэрхийлэхээс татгалзах нь тохиромжтой юм. Дээрх нөхцөлүүдэд тохиромжтой санал дүгнэлтийг өгөхдөө аудитор баталгаажуулах гэрээт ажлын хувьд тооцоолсон материаллагын түвшинг харгалзан үздэг.

Практикт маш олон төрлийн баталгаажуулах гэрээт ажил байдаг бөгөөд үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагаас үүдэн цаашид ч нэмэгдэх боломжтой. Аудитын компаниас нийтлэг үзүүлдэг баталгаажуулах гэрээт ажлын төрлүүдэд дараах гэрээт ажлууд хамаарч болно.

- Эрсдлийн үнэлгээ,
- Мөнгөний үнэ цэнийн хэмжилт,

- Бизнесийн гүйцэтгэлийн хэмжилт,
- Системийн найдвартай байдлын үнэлгээ,
- Мэдээллийн технологийн асуудал (Цахим худалдаа, технологид суурилсан бизнес).

Ихэнх компани бизнесийн эрсдэлээ өөрөө илрүүлэх, удирдах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлдэг ба эрсдлийг стратегийн, үйл ажиллагааны, мэдээллийн эрсдэл гэж ангилдаг. Компани эрсдлийг тодорхойлж шинжлэн, эрсдлийн тохиолдох магадлал болон өөрийн бизнест нөлөөлөх боломжит нөлөөллийг судалдаг бөгөөд эдгээр хүчин зүйлсийг харгалзан компанийн удирдлага эрсдлийг удирдах боломжит стратегийг боловсруулна. Хэрэв эрсдэл тохиолдох магадлал болон нөлөөлөл нь бага бол эрсдлийг хүлээн зөвшөөрдөг, эрсдлээс үүсэх үр дагавар буюу нөлөөлөл их бол эрсдлийг шилжүүлдэг (даатгуулах эсвэл дотоод хяналыг илүү үр ашигтай зохион байгуулах), эрсдэл тохиолдох магадлал болон нөлөөлөл их бол уг эрсдлээс зайлсхийх гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Мөнгөний үнэ цэнийн хэмжилт гэдэг нь зорилгодоо хүрэхийн тулд нөөцийг хамгийн зөв аргаар зарцуулахыг хэлэх бөгөөд ихэвчлэн компани дотооддоо буюу дотоод аудитын ажилтнаар гүйцэтгүүлдэг. Зарим үед аудитор энэ гэрээт ажлыг гүйцэтгэхээр үйлчлүүлэгчтэй гэрээлэх ба уг гэрээт ажлыг гүйцэтгэхдээ 3Е буюу

дараах агуулга бүхий, үйл ажиллагааг тодорхойлж, харгалзах хэмжилтийг гүйцэтгэж, өөрийн санал дүгнэлтээ илэрхийлдэг (Хүснэгт 3).

Орчин үед компаниуд өөрийн бизнесийн онцлогоос хамааран гүйцэтгэлийг хэмждэг олон шалгуур үзүүлэлт байхыг үгүйсгэхгүй бөгөөд аудиторын хийсэн компанийн гүйцэтгэлийг хэмжсэн ажлын тайлангаас компанийн удирдлага тухайн бизнесийн үйл ажиллагаа нь зорилтдоо хүрсэн эсэхийг мэдэж болдог. Гүйцэтгэлийг хэмждэг жишиг үзүүлэлтэд тухайн жилийн гүйцэтгэл зорилтот түвшин эсвэл төсөвлөсөн түвшинд хүрсэн эсэх, энэ жилийн үр дүнг өмнөх жилийн үр дүнтэй харьцуулах эсвэл өрсөлдөгчийн хүрсэн үр дүнтэй харьцуулах, энэ жилийн борлуулалтыг зорилтот борлуулалтын хэмжээтэй харьцуулах, энэ жилийн ашгийг зорилтот ашгийн хэмжээтэй харьцуулах, өртөг зардлын болон төсөвлөлтийн зөрүүг шинжлэх, бүтээгдэхүүний чанарын өөрчлөлт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн өөрчлөлт, ажилчдын бүтээмжийн өөрчлөлт гэх мэт үзүүлэлтүүд багтана.

Компанийн удирдлага болон хувь нийлүүлэгчид аудиторoor тухайн байгууллагын түвшинд хэрэглэж байгаа мэдээллийн системийн үр ашиг, найдвартай ашиглалтын талаар баталгаа гаргуулахаар гэрээт ажлыг гүйцэтгүүлж болно. Тиймээс аудитор энэ гэрээт ажлыг технологид суурилсан аудитын арга

Хүснэгт 3. 3Е-ийн загвар

3Е	Агуулга	Хэмжилт
Economy буюу хэмнэлт	Хамгийн бага өртгөөр хийх	Зарцуулсан мөнгийг бэлтгэсэн орцтой харьцуулах
Efficiency буюу үр ашиг	Боломжит хамгийн их хэмжээгээр хийх	Хэрэглэсэн орцыг үйлдвэрлэсэн гарцтай харьцуулах
Effectiveness буюу үр дүн	Хийхийг зорьсон зүйлээ хийх	Үйлдвэрлэсэн гарцыг зорилготой харьцуулах

Эх сурвалж: Судалгааны үр дүн

аргачлалаар гүйцэтгэх ба жишээлбэл аудитын программ хангамж эсвэл туршилтийн өгөгдөл зэрэг юм.

Баталгаажуулах гэрээт ажлын олон улсын стандартад Баталгаажуулах гэрээт ажлын тайлангийн бүтцийг дараах байдлаар тодорхойлж өгсөн.

- Баталгаажуулах гэрээт ажлын тайлан,
- Хаяг,
- Баталгааны түвшний тодорхойлолт,
- Гэрээт ажлын шалгах асуудлын тодорхойлолт,
- Тохиромжтой шалгуур,
- Гэрээт ажлын уламжлалт хязгаарлалтууд,
- Тайлангийн хэрэглэгч болон хэрэглээний хязгаарлалт,
- Удирдлагын үүрэг хариуцлага,
- Аудиторын үүрэг хариуцлага,
- АОУС болон холбогдох ёс зүйн дүрмийг даган мөрдсөнөө дурьдах,
- Гүйцэтгэсэн ажлын хураангуй,
- Аудиторын санал,
- Аудиторын гарын үсэг,
- Тайлангийн огноо,
- Аудиторын хаяг.

Дүгнэлт

Аудитын бус үйлчилгээ нь холбогдох үйлчилгээ болон баталгаажуулах гэрээт ажил гэсэн төрлүүдтэй байна. Аудитын холбогдох үйлчилгээ нь дотроо гурван

бүлэгт ангилагдах ба нягтлах гэрээт ажил нь шалгагдаж буй мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлгүй болох талаар хязгаарлагдмал баталгааны түвшинг өгдөг бол бусад хоёр төрөл нь баталгаа өгдөггүйгээрээ ялгаатай байна. Мөн нягтлах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ аудиттай адил санхүүгийн тайлан нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо цуглуулах аудитын горимуудыг хэрэгжүүлдэггүй. Харин баталгаажуулах гэрээт ажил шалгагдсан санхүүгийн мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлгүй болох талаар хязгаарлагдмал болон ул үндэслэлтэй баталгааны түвшинг өгч байгаагаараа холбогдох үйлчилгээнээс ялгаатай бөгөөд уг гэрээт ажлыг гүйцэтгэхэд хэрэгжүүлдэг горим нь мөн өөр байна. Өөрөөр хэлбэл үйлчлүүлэгчийн удирдлага холбогдох үйлчилгээг гүйцэтгүүлэхээр аудиторыг ажиллуулж байгаа бол гэрээт ажлыг гүйцэтгэж байгаа мэдээллийн үнэн зөв, бодит, иж бүрэн байдлыг хариуцаж байдаг. Тиймээс аудитор аудитын холбогдох үйлчилгээг гүйцэтгэхдээ нарийвчилсан тест хэрэгжүүлэлгүй ихэвчлэн шинжилгээний горим болон асуулгын горимыг гүйцэтгэдэг. Бидний хийсэн онолын судалгааны үр дүнг Хүснэгт 4-өөр товч тодорхой харуулахыг зорилоо.

Хүснэгт 4. Аудитын бус гэрээт ажлын онцлог

№	Үзүүлэлт	Аудитын холбогдох үйлчилгээ	Баталгаажуулах гэрээт ажил
1	Баталгааны түвшин	Хязгаарлагдмал эсвэл баталгаа өгөхгүй	Ул үндэслэлтэй эсвэл хязгаарлагдмал
2	Хэрэгжүүлэх горим	Шинжилгээний горим, асуулгын горим	Хяналтын тест, нарийвчилсан тест, шинжилгээний горим
3	Дотоод хяналтын системийг үнэлдэг эсэх	Үгүй	Тийм
4	Дүгнэлт илэрхийлэх хэлбэр	Сөрөг эсвэл дүгнэлт өгөхгүй	Эерэг эсвэл сөрөг
5	Үйлчлүүлэгчийн удирдлагын үүрэг	Мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдал	Мэдээллийг хүргүүлэх

Эх сурвалж: Судалгааны үр дүн

Ашигласан материал

- Accounting Tools (July 4, 2024). *The Difference between an Audit, a Review, and a Compilation*. Retrieved from Accounting Tools: <https://www.accountingtools.com/articles/the-difference-between-an-audit-a-review-and-a-compilation>
- Bowen, J. (2016). *Guide to Review Engagements*. Toronto: Chartered Professional Accountants of Canada.
- Hong Kong Institute of Certified Public Accountants (2021). *Assurance Engagements Other than Audits or Reviews of Historical Financial Information*. Hong Kong.
- McGibbon, D. (May 27, 2021). *Assurance vs Audit: What is the Differences*. Retrieved from AAB group: <https://fpmaab.com/trending-topics/assurance-vs-audit/>
- Moore Markhams (August 14, 2019). *Choosing an Audit or Review*. Retrieved from Moore Markhams: <https://www.markhams.co.nz/publications/audit-and-assurance/preparing-for-a-review>
- Navarro, R. S. (2016). *Philippine Framework for Assurance Engagements*. Auditing Standards and Practices Council.
- The Institute of Chartered Accountants of Nigeria (2021). *Advanced Audit and Assurance, Study Text*. Lagos: Emile Woolf International.
- ММНБИ (2018). Аудитын Олон Улсын Стандарт.
- ММНБИ (2018). Баталгаажуулах Гэрээт Ажлын Олон Улсын Стандарт.
- ММНБИ (2018). Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандарт.